



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ БҮРЭН НОГДУУЛААГҮЙ,
БНАТ-ЫН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨЖ,
ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

АУДИТЫН НЭР: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: СБА-2023/30-13-ШТА-НА

Баруун-Урт 2023 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Оюунболд

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ А. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд зарим эрх зүйн актад өөрчлөлт оруулах шаардлага байна.	5
<i>А.1. Төрөөс ойн талаар баримтлах бодлого зэрэг нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд ногоон хөгжлийн бодлого болон ойн талаар баримтлах бодлогын хэрэгжилт дунджаар 75 хувь байна.</i>	<i>5</i>
<i>А.2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан байна.</i>	<i>7</i>
БҮЛЭГ Б. Ус болон газрын төлбөрийн орлогыг дутуу ногдуулж зардлын 33.3 хувийг зориулалт бусаар зарцуулжээ.	9
<i>Б.1. Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт хуулийн дагуу хэрэгжиж байна.</i>	<i>9</i>
БҮЛЭГ В. Хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ байхгүй, харилцагч талуудын уялдаа холбоо муу байна.	19
<i>В.1. Хуулийн хэрэгжилтийн тайлагнал хангалтгүй, мэдээллийн санг үнэн зөв илэрхийлээгүй, төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байна.</i>	<i>19</i>
<i>В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг дүгнээгүй байна.</i>	<i>20</i>
Холбогдох байгууллагын санал:	23
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	23
ДҮГНЭЛТ: 24	
ЗӨВЛӨМЖ:.....	24
Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:	25

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
МУЗЗНДНТУ	Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	БОАЖГ-ын даргын аймгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ	8
Хүснэгт 2	Сүхбаатар аймгийн ан, амьтны нөөц	10
Хүснэгт 3	Сүхбаатар аймгийн ойн талбай, хэмжээ	11
Хүснэгт 4	Сүхбаатар аймгийн усны нийт нөөц, (шоо метр)	11
Хүснэгт 5	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөг)	15
Хүснэгт 6	Газрын төлбөр ногдуулаагүй уул, уурхайнууд, (төгрөг)	16
Хүснэгт 7	Газрын төлбөрийн ногдуулалт, төлөлт, үлдэгдэл, (төгрөг)	17
Хүснэгт 8	БНАТ-ийн орлогын хэсгийн зарцуулалт, (сая төгрөг)	18

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит үндэслэл, эрх	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын ИТХ, Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Усны сав газрын захиргаа, Татварын хэлтэс, Цагдаагийн газрын 2021-2023 оны үйл ажиллагааг хамруулав. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн хэрэгжилтэд хийх нийцлийн аудитыг аймаг, нийслэлийн аудитын газрын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн аудитын дэд тайлан, илрүүлэлтийн матрицыг боловсруулан Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2023 оны 5 сарын 04-ны өдрөөс 6 сарын 19-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд зарим эрх зүйн актад өөрчлөлт оруулах шаардлага байна.

А.1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД НОГООН ХӨГЖИЛ, ОЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ДУНДЖААР 75 ХУВЬТАЙ БАЙНА.

А.1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль түүнтэй холбогдуулан гарсан зарим эрх зүйн актад өөрчлөлт оруулах шаардлага байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19-р зүйл “Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх”, 19.1.3-т “тариалангийн бүс нутгаас бусад нутагт байгалийн ургамлыг хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага” гэж заасны дагуу ашиг олох болон ахуйн хэрэглээнд хадлан бэлтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас байгалийн нөөц ашигласны төлбөрийг чөлөөлөхөөр тусгасан байна. Ургамалын нөөц ашигласны төлбөрийг ашиг олох зорилготой эсэхээс үл хамааран хадлан бэлдсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөхгүй байх зохицуулалтыг хуульд оруулах шаардлага байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан хугацаанд бүрэн төлдөг болгохын тулд төрийн зарим төрлийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө тухайн иргэн, хуулийн этгээдэд ногдуулсан байгалийн нөөц ашигласны төлбөрийг хууль, шүүхийн маргаантайгаас бусад тохиолдолд төлсөн байх шалгуурыг холбогдох хууль тогтоомжуудад оруулж өгөх шаардлагатай байна. Учир нь газрын төлбөрийн төлөгдөөгүй дүн 2021 оны ногдуулалтын 23.6 хувь буюу 84.9 сая төгрөг, 2022 оны ногдуулалтын 25.1 хувь буюу 103.8 сая төгрөг төлөгдөөгүй байна.

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.11-3.15 дахь заалтад “Аймаг, сумын төсөвт төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө”-г төлөвлөх харилцааг зохицуулсан боловч БНАТ-ийн тухай хуульд энэ талаар зохицуулалт байхгүйн улмаас “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дээрх заалт, зохицуулалт хэрэгжихгүй байх сөрөг үр дагавартай байна. Иймд БНАТ-ийн орлого давсан тохиолдолд давсан орлогын зарцуулалт нь БНАТ-ийн хуулийн 18.1 дэх заалтыг хангасан байх тухай заалтыг БНАТ-ийн хуульд нэмж тусгах шаардлагатай байна.

А.1.2. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт байгалийн нөөцийг ашиглах, нөхөн сэргээх, хамгаалахтай холбоотой баталсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 57-95 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичиг: Аймаг, нийслэл, хотыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 11 арга хэмжээ, үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 8 арга хэмжээг тусгасан ба 2021, 2022 оны хэрэгжилт дунджаар 95 хувьтай байна.

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 38 арга хэмжээ, үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 32 арга хэмжээг тусгасан байна. 2021 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт 85 хувь, 2022 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт 57 хувь байна.

Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, “Ус” үндэсний хөтөлбөр, Ногоон хөгжлийн бодлого, Төрөөс ойн талаар баримтлах бодлого зэрэг нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, зөрчлийг арилгах зорилгоор 2021 оны МУИХ-ын “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 89 дугаар тогтоолоор хүчингүй болсон хэдий ч Сүхбаатар аймгийн хэмжээнд Ногоон хөгжлийн бодлого болон Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 2021 оны хэрэгжилт дунджаар 75 хувь байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын богино хугацааны баримт бичиг: Аймгийн 2021, 2022, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 14-17 арга хэмжээ төлөвлөснөөс 2021 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт 90 хувь, 2022 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт 92 хувь байна.

А.1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан ан, амьтны болон усны менежментийн төлөвлөгөөг батлуулсан байна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан менежментийн төлөвлөгөөг эрх бүхий байгууллагууд баталж хэрэгжүүлэх үүрэгтэй. Менежментийн төлөвлөгөөнд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- Хэрлэн голын сав газрын менежментийн төлөвлөгөөг 2016 онд, Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын менежментийн төлөвлөгөө 2019 онд 2 үе шаттай хэрэгжүүлэхээр, Галба-Өөш-Долоодын говийн сав газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын менежментийн төлөвлөгөөг 2019 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

- Сүхбаатар аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 2021 онд баталж 2025 он хүртэл, Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2023 онд 2037 он хүртэл хэрэгжүүлэхээр, Хар ямаатын улсын хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг 2014, 2018 онуудад байгалийн нөөц болон дурсгалт газрын төлөвлөгөөг 2019 онд батлуулсан байна.
- Ойн тухайн хуульд заасны дагуу ойн сан бүхий аймаг, сум “Ойн менежментийн төлөвлөгөө”-тэй байх шаардлагатай боловч Сүхбаатар аймгийн хэмжээнд “Ойн менежментийн төлөвлөгөө” боловсруулаагүй байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ, БОАЖГ аймгийн “Ойн менежментийн төлөвлөгөө”-г мэргэжлийн байгууллагаар боловсруулж Ойн газраар батлуулах, БОАЖГ болон сумдын ЗДТГ-ууд сумдын “Ойн менежментийн төлөвлөгөө”-г мэргэжлийн байгууллагаар боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулах шаардлагатай байна.

А.2. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГЭРЭЭНД БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ ХАРИЛЦААГ ТУСГАСАН БАЙНА.

А.2.1. БОАЖ-ийн сайд аймаг, нийслэлийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

Аймгийн засаг даргын БОАЖ-ийн сайдтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд 6 зорилтын 61 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан, 2022 онд 8 зорилтын 63 арга, хэмжээ төлөвлөгдсөнөөс үр дүнд хүрсэн 52 заалт, хэрэгжих шатанд байгаа 3 заалт, эрчимжүүлэх шаардлагатай 6 заалт байна. Үүнээс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зарим арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл:

- Тухайн орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН, байгууллагуудыг нийгмийн хариуцлагын хүрээнд зэрлэг амьтдад зориулж хиймэл усан сан бүхий цөөрөм байгуулах талаар санал, санаачилга гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих арга хэмжээний хүрээнд Мөнххаан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг Хунт өгөөж ХХК нь шавхан зайлуулж байгаа усаа хөв цөөрөмд хуримтлуулах зорилгоор мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэж, сумын Засаг дарга болон ИТХ-д хүсэлтээ хүргүүлсэн, биелэлт хангагдаагүй.
- Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг Авралын эрэлд ХХК тай 14.1 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж, аймгийн хэмжээний нэн ховор болон ховор, элбэг амьтдын тархац нөөцийн судалгаатай болж цаашид хэрхэн хамгаалах, өсгөн үржүүлэх талаар менежментийн төлөвлөгөө боловсруулсан.
- Аймаг сумын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах арга хэмжээний хүрээнд “Тэр бум мод”

үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах, аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг 8 зорилтын 40 заалтаар олон нийтийн оролцоотойгоор боловсруулж, аймгийн ИТХ-д санал оруулахаар төлөвлөсөн ч хэрэгжээгүй байна.

- Ургамлын судалгааны тайланд үндэслэн Аймгийн хэмжээнд нэн ховор болон ховор ургамлын жагсаалтыг гаргаж, тэдгээр ургамлыг эмийн болон ахуйн зориулалтаар түүж бэлтгэхийг тодорхой хугацаагаар хориглохоор хүсэлт болон захирамжийг төлөвлөн БОАЖ яаманд хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна.
- Аймгийн хэмжээнд 2022 онд 180 толгой Монгол тарвага сэргээн нутагшуулж тухайн орон нутагт устаж үгүй болсон популяци тоо, толгой, тархац нутгийг нэмэгдүүлсэн.
- Баруун-Урт суманд 5 га-д хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд 3 төрлийн 4000 ш мод тарьснаас 3200 ширхэг мод хэвийн ургаж 800 ширхэг мод хорогдож ургалт 80%-тай байна.
- Аймгийн 2020-2028 оны хөгжлийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 тоот албан даалгавар, 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд нийт 11 булгийг хашиж хамгаалсан байна.

Дэвшүүлсэн зорилтын биелэлтээс ойн сан бий болгох ховордсон ан амьтныг хамгаалах, сэргээн нутагшуулах ажлууд үр дүнд хүрсэн боловч холбогдох дээд байгууллагаар шийдвэрлүүлэх зорилт арга, хэмжээ хэрэгжээгүй байна.

А.2.2. Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд 80 арга хэмжээ, 2022 онд 59 арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжилтийг дүгнэн ажилласан байна.

Хүснэгт 1. БОАЖГ-ын даргын аймгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ

№	Арга хэмжээний зорилт, ангилал	2021	2022
1	Бодлогын баримт бичиг зорилттой холбоотой	15	13
2	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилттой холбоотой	46	46

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн БОАЖГ

Хэрэгжүүлсэн арга, хэмжээнээс ойн сан бий болгох, ховордсон ан амьтныг сэргээн нутагшуулах зэрэг ажлууд үр дүнд хүрсэн боловч аймгийн засаг дарга болон ИТХ-аас Засгийн газар болон БОАЖ-ын яаманд хүргүүлсэн ажил хэрэгжээгүй, ажлын явц удаашралтай байна.

Аймгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ундны усаар хангаж буй “Дөрвөлж” ОНӨААТҮГ-ын усны алдагдлыг /эх үүсвэрээс олборлосон усны 30 орчим хувь, хэрэглэсэн усны 40 орчим хувьтай тэнцэх буюу 3 жил тутамд Баруун-Урт сумын хэрэглэгчдийн 1 жилд хэрэглэх усыг шугамын алдагдлаар алддаг/ бууруулах ажлыг зохион байгуулах, алдагдсан уснаас төлбөр авах шаардлага байна. Усны алдагдлыг бууруулах, цаашид бүрэн зогсооход хэдэн төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай, усны алдагдалгүй болсноор алдагдсан боломжит өртгийг хэдий хугацаанд бүрэн нөхөх зэрэг эдийн засгийн үр өгөөжийг тооцохын тулд “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 19 дүгээр зүйл “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээ”, 19.1 дэх заалт “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана:”, 19.2 дахь заалт “эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин;”, 19.3 дахь заалт “техник, технологийг шинэчлэх даалгавар;”-ын дагуу захиралтай байгуулах гэрээнд тусгаж усны алдагдлыг бууруулах зайлшгүй шаардлага байна.

БҮЛЭГ Б. УС БОЛОН ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ДУТУУ НОГДУУЛЖ ЗАРДЛЫН 33.3 ХУВИЙГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛЖЭЭ.


Б.1. ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭНЭЭС БАГААР ТӨЛӨВЛӨЖ БАТАЛСАН БАЙНА.

Б.1.1. Байгалийн нөөцийн хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагууд судалж тогтоосон байна.

Ургамлын нөөц:

Сүхбаатар аймагт ургамлын зүйлийн жагсаалтыг 2021 оны байдлаар нийт 63 овог, 245 төрөл, 550 зүйл ургамал бүртгэсэн ба үүнээс нэн ховор ургамал 7, ховор ургамал 27, элбэг ургамал 516 зүйл тогтоогдсон байна. Сүхбаатар аймгийн хэмжээнд бэлчээрийн 19.0 хувьтай тэнцэх талбайд эмийн ашигт ургамал маш таруу тархсан, малын бэлчээрлэлтээс болж ашиглах нөөцгүй болсон байна. Эмийн ашигт ургамлын биологийн ургац 2 ц/га –аас бага бол “Нөөцгүй” зэрэглэлд ордог бөгөөд Сүхбаатар аймгийн хэмжээнд ургамалжлын тархцыг сумдаар авч үзэхэд 0.02-0.8 ц/га тархацтай байгаа тул эмийн ашигт ургамлын биологийн нөөцгүй гэж мэргэжлийн байгууллага тогтоожээ.

Малын тоо толгой нэмэгдсэнтэй холбоотойгоор Эрдэнэцагаан сумаас бусад нь бэлчээрийн даац хэтрэлттэй бөгөөд Асгат, Мөнххаан, Наран, Халзан сумд 50 хувь хүртэл хэтрэлттэй, Онгон, Сүхбаатар, Уулбаян сумд 50-100 хувь хүртэл, Баяндэлгэр, Дарьганга, Түвшинширээ, Түмэнцогт сумдын зун намрын улирлын бэлчээрийн даац 100-аас дээш хувиар хэтэрсэн гэж мэргэжлийн байгууллага тогтоосон байна. Бэлчээрийн даац хэтэрсэн нь



бэлчээрийн доройтлын суурь шалтгаан бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 9.6 хувь нь их талхлагдсан, 28.7 хувь нь дунд зэрэг талхлагдсан, 61.1 хувь нь бага зэрэг талхагдалд өртсөн байна.

Ан амьтны нөөц:

Сүхбаатар аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаагаар аргаль хонь 73, халиун буга 906, бор гөрөөс 62, монгол тарвага 365, цагаан зээр 215,950, хар сүүлт 454, нийт 217,810 тоо толгой амьтан бүртгэгдсэн байна. Мөн хээрийн судалгааны явцад саарал чоно, шар үнэг, хярс, бор туулай, өмхий хүрэн, мануул, халздай дорго зэрэг амьтад тодорхой хэмжээгээр бүртгэгдсэн байна. Аймгийн хэмжээнд ахуйн зориулалтаар жилд 620 хүртэл тооны цагаан зээрийг ахуйн зориулалтаар агнан ашиглах боломжтой, бусад ан амьтны хувьд агнуурын нөөцгүй гэж мэргэжлийн байгууллага тайлагнажээ.

Хүснэгт 2. Сүхбаатар аймгийн ан, амьтны нөөц

№	Нэр төрөл	Байршил	Нутаг дэвсгэр км.кв	Тоо толгой /орчим/	Нягтшил 1000 га-д
1	Аргаль хонь	Сүхбаатар, Дарьганга, Онгон, Түвшинширээ, Мөнххаан сумд	154.7	73+-14	0.6
2	Халиун буга	Түмэнцогт-Хар ямаатын Байгалийн нөөц газар, Эрдэнэцагаан сум-Лхачинвандад Байгалийн нөөц газар	785.4	906+-40.9	1.04
3	Бор гөрөөс	Эрдэнэцагаан, Түмэнцогт	785	62+-7	0.15
4	Монгол тарвага	Мөнххаан, Түмэнцогт, Халзан, Сүхбаатар, Дарьганга, Эрдэнэцагаан	293.4	365+-28	
5	Цагаан зээр	Бүх сумдад	6,267	215950+-5398	64,785
6	Хар сүүлт	Баяндэлгэр, Онгон, Халзан	830	454+34	120
НИЙТ ДҮН				217,810	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн БОАЖГ, Ан амьтны менежментийн төлөвлөгөө

Амьтны тухай хуулийн 26.1."Төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг, энэ хуулийн 5.3.2, 5.8.1-д заасан агнуурын амьтны нөөц, хэрэгцээг харгалзан аймаг, нийслэл тус бүрээр тогтооно". гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар Сүхбаатар аймагт ахуйн зориулалтаар агнах цагаан зээрийн тооны дээд хэмжээг тогтоосон байна. Тодруулбал 2021 онд 200, 2022 онд 300, 2023 онд 300 цагаан зээр агнах дээд хэмжээг тус тус тогтоожээ. Ахуйн зориулалтаар агнах зээрийн дээд хэмжээ нь мэргэжлийн байгууллагын судалгаагаар тогтоосон хэмжээний 50 хувиас бага байгаагаас үзэхэд цагаан зээр агнах дээд хэмжээг үндэслэлтэй тогтоосон байна.

Ойн сан бүхий газар:

Ойн тухай хуулийн 3.1.1."ой" гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг; 3.1.2."ойн сан" гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор

байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг; 3.1.3."ойн нөөц" гэж ойг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлснийг; 3.1.4."ашиглах нөөц" гэж ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгөөр тодорхой хугацаанд авч ашиглаж болох модны дээд хэмжээг хэлнэ гэж заасан. Сүхбаатар аймгийн хэмжээнд ойн ашиглах нөөцгүй бөгөөд Дарьганга 15,187 га, Түмэнцогт 67 га, Эрдэнэцагаан суманд 410 га нийт 15,664 га талбай бүхий ойн сантай. Үүнээс: Ойгоор бүрхэгдсэн-2,218 га ойгоор бүрхэгдээгүй-13,446 га талбайтай байна.

Хүснэгт 3. Сүхбаатар аймгийн ойн талбай, хэмжээ

Ойн талбай-15,664 га			
Ойгоор бүрхэгдсэн-2,218 га		Ойгоор бүрхэгдээгүй газар-13,446 га	
Үүнээс:	Байгалийн ой-635 га	Үүнээс:	Таримал мод-13,445 га
	Таримал ой-16 га		Ойжуулсан талбай-1 га
	Бут сөөг-1,567 га		

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

Усны нөөц:

Сүхбаатар аймгийн БОАЖГ, сав газрын захиргаанаас хийсэн 2020-2021 оны усны тооллогын мэдээгээр нийт 354 нуур байгаагаас 109 нь усгүй, ширгэсэн хуурай тойром, 11 нуур ширгэсэн байгаад сэргэсэн байна. Нийт 32 гол горхи байгаагаас 12 нь түр зуурын урсацтай, 3 нь тасарсан, 1 нь ширгэсэн байна. Нийт 248 булаг 9 рашаан байгаагаас 49 булаг хамгаалагдсан, 90 булаг хамгаалах шаардлагатай, 46 булаг газрын онцлог буюу байгалийн аясаар хамгаалагдсан байна. БОАЖ-ийн сайдын тушаалаар 2010 онд Монгол орны нутаг дэвсгэрийг 29 усны сав газарт хуваасан бөгөөд Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрийг хамран үйл ажиллагаа явуулж байгаа Буйр нуур-Мэнэнгийн талын сав газар, Галба-Өөш-Долоодын говийн сав газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар, Хэрлэн голын сав газар гэсэн 4 сав газар байна. Дээрх сав газрууд 2-3 үе шаттай хэрэгжүүлэх усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан баталж 2021, 2022 оны хэрэгжилт 90-100 хувьтай байна.

Хүснэгт 4. Сүхбаатар аймгийн усны нийт нөөц, (м.куб/жил)

№	Сав газрын нэр	Ус, рашаан							
		2021 он				2022 он			
		Усны нийт нөөц	түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээ	Гадаргын уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаар тогтоосон хэмжээ	Газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаар тогтоосон хэмжээ	Усны нийт нөөц	түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээ	Гадаргын уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаар тогтоосон хэмжээ	Газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаар тогтоосон хэмжээ
1	Галба-Өөш-Долоодын говийн сав газар	54,173	8,145	567	7,578	54,173	8,145	567	7,578
2	Буйр нуур, халх гол, мэнэнгийн талын сав газар	560,531	420,900	54,900	366,000	560,531	420,900	54,900	366,000
3	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар	55,185	6,402	-	4,481	55,185	6,402	-	4,481
4	Хэрлэн голын сав газар	129,770	121,241	-	121,241	129,770	121,241	-	121,241
Нийт		799,659	556,688	55,467	499,301	799,659	556,688	55,467	499,301

Эх сурвалж: Усны сав газруудаас авсан судалгаа

Дээрх 4 сав газрын бүртгэлээр 2023 оны байдлаар Сүхбаатар аймгийн усны нийт нөөц 799.6 м.куб, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээ 556.7 м.куб ба үүнээс гадаргын уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаар тогтоосон хэмжээ 55.5, газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаар тогтоосон хэмжээ 499.3 м.куб байна.

Б.1.2. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээнээс багаар төлөвлөж баталсан байна.

“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу БОАЖГ-аас 2022 оны 10 дугаар сарын 06 ны өдрийн 202 албан тоотоор 2023 онд ахуйн зориулалтаар 300 толгой цагаан зээр агнах хүсэлтийг БОАЖЯ-нд хүргүүлж БОАЖЯ-ны сайдын А/05 тушаалаар аймгийн хэмжээнд 300 толгой цагаан зээр ахуйн зориулалтаар агнах дээд хэмжээ олгогдсон байна.

Мөн дээрх журамд заасны дагуу Сүхбаатар аймгийн ИТХ-ын тогтоолоор 2021 оны ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг 400.0 сая төгрөгөөр, 2022 онд 500.0 сая төгрөгөөр, 2023 онд 520.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Орлогын төлөвлөгөөг БНАТ-1 маягтын дагуу сумаас татварын болон байгаль орчны хяналтын улсын байцаагч, БНАТ-3 маягтын дагуу хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөж, БНАТ-5 маягтын дагуу аймгийн төсвийн саналд тусгахаар албан бичгээр аймгийн засаг даргад хүргүүлсэн байна.

Б.1.3. Газрын гүний усыг зөвшөөрөлгүй ашиглах болон газар эзэмших зөвшөөрөлгүйгээр нийтийн эдэлбэр газар болон зам, шугам сүлжээний газрыг ашиглах зөрчил нийтлэг байна.

Усны тухай хуульд ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг "ус ашиглагч" гэж, ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчныг ашигладаг хэрэглэгчийг "ус хэрэглэгч" гэж тус тус тодорхойлжээ.

Ус хэрэглэгчид олгох зөвшөөрөл:

Ус хэрэглэгчид зөвшөөрөл олгох харилцааг Усны тухай хуулийн 27 дугаар зүйлээр зохицуулсан байна. Усны тухай хуулийн 27.1-д “Цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах зөвшөөрлийг ус хэрэглээний тоо хэмжээ, чанарыг үндэслэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба ус хэрэглэгчид олгоно” гэж заасан.

Сүхбаатар аймаг дахь худгийн мэдээллийг авч үзэхэд БОАЖГ-аас ирүүлсэн мэдээллээр инженерийн хийцтэй худаг 959, энгийн худаг 1297, нийт 2256 худаг байна. Инженерийн хийцтэй худагт ус ашиглах зөвшөөрөл авах бөгөөд инженерийн

хийцтэй худаг 959 худгаас 158 худаг нь зөвшөөрөлтэй, бусад 801 худаг зөвшөөрөлгүй байна. Энэ нь Усны тухай хуулийн 27.4 дэх “Ус хэрэглэгч ашиглалтын зориулалтыг өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр цооног өрөмдөх, худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглоно” заалт бүрэн хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Ус ашиглагчид олгох зөвшөөрөл:

Ус ашиглагчид зөвшөөрөл олгох харилцааг Усны тухай хуулийн 28 дугаар зүйлээр зохицуулсан байна. Аймгийн хэмжээнд ус ашиглах зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд цөөнгүй байна. Үйл ажиллагааны нэр төрлөөр ангилбал дараах газрууд байна. Үүнд:

- Бетон зуурмагийн үйлдвэрүүд
- Автомашин угаалгын газрууд
- Мал нядалгааны газрууд
- Цэвэр усны үйлдвэрүүд
- Уул уурхай компаниуд
- Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд
- Дарьганга, Онгон, Наран сумдын дулаан хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг ОНӨААТҮГ-ууд
- Блокны үйлдвэр гэх мэт ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулж буй бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллага байна.

Ус зөвшөөрөлгүй ашиглаж байгаа нь Усны тухай хуулийн 28.18 дахь “Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно” заалттай нийцэхгүй байна.

Мөн Усны тухай хуулийн 28.7-д “Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна.” гэж заасан, гэтэл Сүхбаатар, Түмэнцогт, Халзан, Эрдэнэцагаан сумын ус, дулаан хангамжийн үйл ажиллагаа эрхэлдэг ОНӨААТҮГ-ууд ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээгүйгээр төвлөрсөн усан хангамжийн үйл ажиллагаа явуулж байна.

Газрын зөвшөөрөл:

Газрын тухай хуулийн 12.2-т “Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна”. гэж заасан.

Нийтийн эдэлбэр газрууд зөвшөөрөлтэй эсэхийг “Газар эзэмшигчийн улсын бүртгэл”-ээс авч үзэхэд аймгийн хэмжээнд 9 тоглоомын талбай, 2 хог хаягдлын цэг, 7 ногоон байгууламж, 6 нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар, 7 наадмын талбай газрын зөвшөөрөлтэй бусад нь зөвшөөрөлгүй байна

Газрын тухай хуулийн 13.1-д “Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна”. гэж заасан. Сүхбаатар аймгийн хэмжээнд зам, шугам сүлжээний газрыг зөвшөөрөлгүй ашиглаж байгаа зөрчил багагүй байна. Тухайлбал уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт хийж буй авто замууд, төв суурин газрын доторх болон хоорондох цахилгаан, холбооны шугам сүлжээний зориулалтаар ашиглагдаж байгаа газрууд зөвшөөрөлгүй байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай, ногоон байгууламж, зам, шугам сүлжээний газрууд зөвшөөрөлгүй байх зөрчил нийтлэг байна. Энэ нь Газрын тухай хуулийн 27.4 дэх “Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно”. заалттай нийцэхгүй байна.

Амьтны нөөц ашиглах зөвшөөрөл:

“Шонхор” шувууг тусгай зориулалтын агнуур амьтныг агнах, барих зөвшөөрлийг БОАЖЯ-наас, цагаан зээрийг ахуйн зориулалтаар агнах зөвшөөрлийг сумдын Засаг дарга нар олгодог байна. Амьтны тухай хуулийн 25.1-д “Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч, гэрээ байгуулна”. гэж заасны дагуу зөвшөөрөл олгож, гэрээ байгуулдаг байна.

Ой болон ургамлын нөөц ашиглах зөвшөөрөл:

Сүхбаатар аймаг ойн сан бүхий газартай боловч ойн нөөц нь Ойн тухай хуулийн 3.1.4-д заасан “ашиглах нөөц”-ийн хэмжээнд хүрдэггүй байна. Ашиглах нөөц гэж ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгөөр тодорхой хугацаанд авч ашиглаж болох модны дээд хэмжээг хэлдэг байна. Мөн эмийн ашигт ургамлын биологийн нөөцгүй буюу эмийн ургамлын тархац ашиглах хэмжээнд хүрдэггүй байна.

Сүхбаатар аймгийн 13 сумын нийт 8,278,518.3 га бэлчээрийн талбайд мэргэжлийн байгууллагын хийсэн ургамалжлын судалгаа /2021 он/-наас авч үзэхэд дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр нутаг 32.6 хувь, тал хээрийн бэлчээр нутаг 52.2 хувь, довцог элсний бэлчээр 1.1 хувь, цөлөрхөг хээрийн бэлчээр нутаг 6.9 хувь, бүс дундын голын хөндий, нам хоотсын нугын бэлчээр 7.2 хувийг эзэлж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19.1-т “Дараах зориулалт, хэрэгцээгээр байгалийн ургамлын нөөц ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө.” 19.1.3-т “тариалангийн бүс нутгаас бусад нутагт байгалийн ургамлыг хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага”.

гэж заасан. Сүхбаатар аймгийн сумд тариалангийн бүс нутагт хамаардаггүй тул байгалийн ургамлыг хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан тохиолдолд байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөхөөр байна.

Б.1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдуулалтыг дутуу хийсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт:

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан болон ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын 2021, 2022 оны тайлангаас авч үзэхэд БНАТ-ийн төлбөрийн орлогын төлөвлөлт жил бүр 600-800 сая төгрөгөөр нэмж төлөвлөж байгаа боловч орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 2021 онд 1.6, 2022 онд 0.5 дахин давсан байна. БНАТ-ын төлбөрийн орлогын гүйцэтгэлийн 40-60 хувийг ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого эзэлж байгаа бөгөөд энэ нь шонхор агнуулсны төлбөрийн орлого дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөг)

№	БНАТ-ийн орлогын бүрдүүлэлт	Төлөвлөгөө			Гүйцэтгэл		
		2021	2022	2023	2021	2022	2023
1	Байгалийн ургамал ашигласны төлбөр	20.00	48.50	41.00	71.50	56.10	-
2	Рашаан, ус ашигласны төлбөр	422.60	515.30	533.90	614.20	603.10	-
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	123.00	476.20	1,282.70	1,039.60	1,366.30	-
4	Газрын төлбөр	445.80	520.30	539.80	706.00	309.30	-
НИЙТ ДҮН		919.45	1,560.30	2,397.49	2,431.34	2,334.81	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗДТГ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт:

Газар эзэмшигчийн улсын бүртгэлийн мэдээллийн санг газрын төлбөр ногдуулалтын программ хангамжийн мэдээлэлтэй тулгаж үзэхэд 2021 онд 116 нэгж талбарын газар эзэмшигчид ногдуулах 71.4 сая төгрөг, 2022 онд 345 нэгж талбарын газар эзэмшигчид ногдуулах 40.3 сая төгрөгийн газрын төлбөрийг ногдуулаагүй байна. Орлого ногдуулаагүй дээрх зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн хэмжээнд ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан 68 уурхай байгаагаас 13 уурхай Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлөөгүй байна. Учир нь газрын төлбөр ногдуулалтын программ хангамжид ногдуулалт үүсгээгүй, газар ашиглагч хуулийн этгээдийн улсын бүртгэлд 11 уурхайг бүртгээгүй, 2 уурхай бүртгэлтэй боловч ногдуулалт хийгээгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 10-р сарын 01-ний өдрийн 04 тоот тогтоолоор уурхайн газарт ашиглалт, олборлолт явуулж буй талбай, уул, уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламж, уурхайн нөөц газар, тэсрэх бодисын агуулах гэсэн 4 ангиллаар

газрын төлбөр авахаар тусгасан. Дээрх 13 уурхайн 2021 оны байдлаар газрын төлбөр төлбөл зохих хэмжээг хүснэгтээр харуулбал: Хүснэгтээс харахад 2021-2022 онуудад газрын төлбөр төлөөгүй бөгөөд нийт 635.6 сая төгрөг байна.

Хүснэгт 6. Газрын төлбөр ногдуулаагүй уул, уурхайнууд, (төгрөг)

Талбайн нэр	Сумууд	Эзэмшигч	Талбайн хэмжээ (га)	1 га талбайн төлбөр	ГТХуулийн 7.4 заалтаар	Нийт төлбөл зохих дүн
Зараа	Сүхбаатар	Анандбаян тал	94.00	16,000	32,000	3,008,000
Өвөр баян	Эрдэнэцагаан	Баян-Эрч	88.46	16,000	32,000	2,830,720
Өлзийт	Мөнххаан	ЭБЭ	130.99	16,000	32,000	4,191,680
Хавцал	Түвшинширээ	ЭБНЭ	25.20	16,000	32,000	806,400
Хөхтий нуруу-3	Эрдэнэцагаан	Эрдэнийн олз	51.47	16,000	32,000	1,647,040
Хулман нуур	Эрдэнэцагаан	Эрдэнийн босго	1,228.66	16,000	32,000	39,317,120
Хүрэн уул	Баяндэлгэр	Талын элч	2,719.94	16,000	32,000	87,038,080
Хэрмийн цагаан өндөр	Эрдэнэцагаан	Эрэн толгой	3,251.05	16,000	32,000	104,033,600
Цагаан ширээ	Уулбаян	Шинэ уужим орд	862.39	16,000	32,000	27,596,480
Цайрт	Түмэнцогт	Говьмастер	288.38	16,000	32,000	9,228,160
Цогт толгой	Сүхбаатар	Цайртминерал	1,015.33	16,000	32,000	32,490,560
Эрвэн хошууны овоо	Сүхбаатар	Каскейд майнинг	77.75	16,000	32,000	2,488,000
Эргэн	Баруун-Урт, Сүхбаатар	Олондавна	98.51	16,000	32,000	3,152,320
Дүн			9,932.13			317,828,160

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ГХБХБГ

Иймд ИТХ-ын тогтоолын дагуу газрын кадастрын зураглалыг дээрх 4 ангиллаар хийлгүүлж 13 уурхайгаас төлбөрийг нөхөн төлүүлэхээр албан шаардлага хүргүүллээ.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс газрын төлбөрийн ногдуулалтад хяналт тавих үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн нь Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх “Татварын алба Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн **ногдуулалт**, төлөлтөд хяналт тавина” заалттай нийцэхгүй байна.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ийн шугамын усны алдагдал 2021 онд нийт олборлосон усны 33.3 хувь буюу 146,207 м.куб, 2022 онд нийт олборлосон усны 28 хувь буюу 110,711 м.куб байгаа бөгөөд шугамын усны алдагдалд ус ашигласны төлбөр ногдуулдаггүй байна. Шугамын усны алдагдал нь жилд дунджаар олборлосон усны 30 орчим хувь буюу 130,000 м.куб ус байна. Хэрэв алдагдаж байгаа усыг эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан тохиолдолд /1 м.куб тутамд 55.5 төгрөг/ 7.2 сая төгрөг, ашигт малтмал олборлох, баяжуулах үйлдвэрлэлд ашиглуулсан тохиолдолд /1 м.куб тутамд 2,331 төгрөг/ 303.0 сая төгрөгийн ус ашигласны төлбөрийн орлого олох боломжтой дүйцэж байна.

Дөрвөлж ОНӨААТҮГ-ийн ус хэрэглэгчдээс ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ус ашигласны төлбөрийг нэхэмжилж авдаггүй байна. Тодруулбал Дөрвөлж ОНӨААТҮГ тэдгээр ус ашиглагчдын өмнөөс төлбөрийг төлсөн байна. Ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан нийт усны төлбөр нь жилд дунджаар 750 орчим мянган төгрөг байна.

Цайрт минерал ХХК 2022 оны 12-р сарын усны нөөц ашигласны төлбөрийг 35.5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30

дугаар зүйлийн 30.7 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 416 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд “7 дахь заалтын "б) зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах" гэсэн дэд заалтын "газрын доорх усанд" баганын "20" гэснийг "35" гэж өөрчилсүгэй”-гэж заасныг зөрчсөн байна. Тус компани дээрх зөрчлийг арилгаж, аудитын хугацаанд орон нутгийн төсөвт 35.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төвлөрүүлэлт

Газрын төлбөрийн төлөгдөөгүй дүн 2021 оны ногдуулалтын 23.6 хувь буюу 84.9 сая төгрөг, 2022 оны ногдуулалтын 25.1 хувь буюу 103.8 сая төгрөг төлөгдөөгүй байна. Тодруулбал: Газар эзэмшиж, ашигласны төлбөрийн 2021-2022 оны ногдуулалт, төлөлтийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 7. Газрын төлбөрийн ногдуулалт, төлөлт, үлдэгдэл, (төгрөг)

Он	Газрын төлбөр төлөгч	Газрын алба Ногдуулалт	Газрын алба Төлөлт	СТСХ-ийн орлогын гүйцэтгэл	Үлдэгдэл	Үлдэгдлийн ногдуулалтад эзлэх хувь
2021	Иргэн	19,875,064	12,562,686	706,056,701	7,312,378	36.8
	Хуулийн этгээд	340,479,093	262,895,221		77,583,872	22.8
	Дүн	360,354,157	275,457,907		84,896,250	23.6
2022	Иргэн	32,038,770	20,657,911	309,338,570	11,380,859	35.5
	Хуулийн этгээд	381,966,640	289,561,723		92,404,917	24.2
	Дүн	414,005,410	310,219,634		103,785,776	25.1
Нийт дүн		774,359,567	585,677,541	1,015,395,270	188,682,026	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Татварын хэлтэс

Газрын төлбөрийн ногдуулалт хийсэн боловч төсөвт төвлөрүүлээгүй газрын төлбөрийн 188.7 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх, хяналт тавих чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх зөвлөмжийг ГХБХБГ, Татварын хэлтэст хүргүүлээ.

Б.2. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээнээс бага төлөвлөж батлагдсан төсвийн 33 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Б.2.1 Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээнээс бага зарцуулахаар төлөвлөжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2021 онд 2,431.3 сая төгрөг төвлөрч БНАТ-ийн тухай хуулийн дагуу 850.4 сая төгрөг зарцуулахаас 317.9 сая төгрөг баталж, зарцуулбал зохих хэмжээний 37.4 хувийг, 2022 онд 2,334.8 сая төгрөг төвлөрч хуулийн дагуу 949.0 сая төгрөг зарцуулахаас 962.7 сая төгрөг баталж 101.4 хувьтай байна.

2021 онд газрын төлбөрийн 706.0 сая төгрөгийн орлогын 105.9 сая төгрөг зарцуулахаас 90.3 сая төгрөг, усны нөөц ашигласны төлбөрийн орлогын 214.0 сая төгрөг зарцуулахаас 52.5 сая төгрөг, ан амьтны нөөцийн орлогын 519.8 сая төгрөг

зарцуулахаас 87.6 сая төгрөг зарцуулсан нь хуулийн хэрэгжилтийг хангаагүйг харуулж байна.

Хүснэгт 8. БНАТ-ийн орлогын хэсгийн зарцуулалт, (сая төгрөг)

Д/д	БНАТ-ийн орлогын бүрдүүлэлт	Гүйцэтгэл		Зарцуул бал зохих хувь	Үүнээс:			
					Зарцуул бал зохих	Зарцуул сан	Зарцуул бал зохих	Зарцуул сан
		2021	2022		2021		2022	
1	Байгалийн ургамал ашигласны төлбөр	71.5	56.1	15	10.73	22.0	8.42	0
2	Рашаан, ус ашигласны төлбөр	614.2	603.1	35	214.97	52.5	211.09	87.6
3	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1039.6	1366.3	50	519.8	87.6	683.15	521.2
4	Газрын төлбөр	706	309.3	15	105.9	90.3	46.40	151.1
	НИЙТ ДҮН	2431.3	2334.8		851.40	252.40	949.05	759.90

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗДТГ, БОАЖГ, сумдын ЗДТГ

2022 онд ан амьтны нөөцийн орлогын зарцуулалт 521.2 сая төгрөг буюу зарцуулбал зохих орлогын 76.2 хувь, усны нөөц ашигласны орлогын зарцуулалт 87.6 сая төгрөг буюу 41 хувийг зарцуулж хуульд заасан хувь хэмжээнээс бага зарцуулалттай байна. Харин газрын төлбөрийн орлогын зарцуулалт 151.1 сая төгрөг буюу 325.6 хувиар илүү байна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд 2021 онд 33 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас менежментийн төлөвлөгөөнд 6 арга хэмжээ, 2022 онд 48 арга хэмжээнээс менежментийн төлөвлөгөөнд 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

БОАЖЯ тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш агнуулах ан амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг баталж байна. Тодруулбал ахуйн зориулалтаар 2021 онд агнах, барих, амьтдын тоо хэмжээний дээд хязгаарыг 2020.12.30-ны өдөр, 2022 оны дээд хязгаарыг 2022.04.08-ны өдөр, 2023 оны дээд хязгаарыг 2023.01.11-ний өдөр тус тус баталсан байна. Агнуулах ан амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг төсвийн цаглабартай уялдуулан батлах шаардлагатай байна.

Б.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд батлагдсан төсвийн 33.3 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд 2021-2022 онуудад 1,799.5 сая төгрөгийг аймаг сумдын ИТХ-аас байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулахаар тусгасан байна. Гарсан гүйцэтгэлийг авч үзвэл хөрөнгө бэлтгэхэд 12.0, шатахуунд 38.6, тоног төхөөрөмж худалдан авахад 150.3, сургалт сурталчилгаанд 23.0, томилолтод 20.8, урамшуулалд 45.4, гэрээний дагуу ажил гүйцэтгэхэд 242.7, өвс тэжээл хужир шүү бэлтгэхэд 4.8, хог цэвэрлэгээнд 35.1, гамшгаас хамгаалахад 17.9, цагдаагийн үйл ажиллагааг дэмжихэд 22.0 нийт 600.6

сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь баталсан зардлын 33.3 хувийг эзэлж байна.

БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтад тусгасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаараас бусад орлогын хэсгийг зарцуулах эрх орон нутагт олгогдсон. Төсвийн тухай хуулийн 23.8 дахь заалт “Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”,-ын дагуу БНАТ-ийн орлого сумын орлогод хамаардаг бөгөөд энэ хүрээнд 2,966.7 сая төгрөгийн орлогыг аймаг сумд өөрсдийн эрхийн хүрээнд зарцуулахаар байна. Өөрөөр хэлбэл байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд батлагдсан зардлыг зориулалтын дагуу 100 хувь зарцуулах боломжтой байна.

БҮЛЭГ В. Хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ байхгүй, харилцагч талуудын уялдаа холбоо хангалтгүй байна.

В.1. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАГНАЛ ХАНГАЛТГҮЙ, МЭДЭЭЛЛИЙН САНГ ҮНЭН ЗӨВ ИЛЭРХИЙЛЭЭГҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

В.1.1 Ил тод байдал хангагдсан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй, мэдээллийн сан бүрдүүлэлт дутуу байна.

Байгаль орчны мэдээллийн санд байршуулсан мэдээллүүд нь шинэчлэгдээгүй байна. Тухайлбал Амьтны мэдээллийн санд амьтны гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл 2015, 2016, 2017 онуудад нийт 4 мэдээлэл бүртгэгдсэн, хамгаалах арга хэмжээний мэдээлэл байхгүй байгаа нь мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг тухай бүр хийдэггүй байна.

Байгалийн ургамлын мэдээллийн санд ургамал хамгаалах арга хэмжээний мэдээлэл, ургамлыг нь ашигласан газрын нөхөн сэргээлтийн мэдээлэл, ургамлын биомассын мэдээлэл байхгүй, ургамлын арав хоногийн ажиглалтын мэдээлэл 2020 оны хэмжилт хийсэн мэдээлэл оруулсан байна.

Байгаль орчны холбогдолтой гэмт хэргийн зөрчлийн мэдээллийн санд Сүхбаатар аймгийн хувьд 1 зөрчил бүртгэгдсэн бөгөөд 2019 оноос хойш мэдээлэл шинэчлэгдээгүй, дахин бүртгэл хийгээгүй байна.

Ус, рашааны мэдээллийн санд Мэнэнгийн тал сав газрын хувьд 2020 оны уст цэгийн тооллогын мэдээллийг оруулсан байна. 2020 оноос хойш тооллого хийгээгүй байна.

Ойн сан бүхий газрын талбай, түүний өөрчлөлт /ОМ-1/-д 2011, 2012 онд мэдээллүүд орсон байна. Харин ойн сан бүхий газрын талбай хэмжээнд өөрчлөлт ороогүйн улмаас мэдээллийн сангийн мэдээлэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйл /Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага: 1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна. 2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчны мэдээллийн төв байх бөгөөд уг төв нь улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний байгууллага байна/-ийн заалт хэрэгжихгүй байна.

В.1.2 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоо муу байна.

Аймгийн CTCX, татварын хэлтсийн мэдээгээр байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2,573.0 сая төгрөг, БОАЖГ-аас eis.mn/finance/ системд оруулснаар 1,290.9 сая төгрөг байна. Зардлын гүйцэтгэлийг eis.mn/finance/ системд CTCX, татварын хэлтсийн гүйцэтгэлээс 471.5 сая төгрөгөөр дутуу буюу 499.0 сая төгрөгөөр мэдээлсэн. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний орлого, зардлын гүйцэтгэлийг мэдээллийн санд 2022 оноос эхлэн оруулж байгаа бөгөөд үнэн зөв оруулаагүйгээс мэдээллийг нэгдсэн байдлаар татаж авах боломжгүй, дутуу оруулсан байна.

Газрын нэгдмэл сангийн мэдээллээр газрын төлбөр төлсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллага 2021 онд 275.4 сая төгрөг, CTCX-ийн гүйцэтгэлээр 706.0 сая төгрөг, 2022 онд 310.2 сая төгрөг CTCX-ийн гүйцэтгэлээр 309.3 сая төгрөг төвлөрсөн байна. Газрын төлбөрийн тухай хуулийн 10.4 дэх заалтад Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавихаар тусгасан боловч газрын төлбөрийн ногдуулалтад хяналт хийгээгүй, CTCX, ГХБХБГ, Татварын хэлтсийн хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

Аймгийн БОАЖГ өөрийн санаачилгаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох, аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг хамруулсан нэгдсэн дэлгэрэнгүй мэдээллийн санг үүсгэж, хөтөлж, тэрхүү мэдээллийн сангийн өгөгдөлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

В.2. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ ҮР ДҮНГ ДҮГНЭЭГҮЙ БАЙНА.

В.2.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мэргэжлийн байгууллага нь байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд хяналт хийсэн боловч, төлбөрийн орлогын бүрдүүлэлт гарсан зардалд хяналт тавиагүй байна.

Аймгийн засаг дарга БОАЖ-ын сайдтай байгуулсан гэрээний дагуу Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор байгаль орчны салбар болон

хууль хяналтын байгууллагууд хамтарсан хууль бус ашигт малтмал 14, ой хээрийн түймрийн эрсдэлийн бэлэн байдалд 1, хог хаягдал 1, ус ашиглалт 2, хууль бус ан агнуур 2 нийт 20 удаагийн хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.

Шалгалтаар Байгаль орчны эсрэг үйлдэгдсэн Зөрчлийн болон Эрүүгийн 12 хэрэгт шинжээчээр томилогдон хяналт шалгалт хийж шинжээчийн дүгнэлт гарган ажилласан байна. Сүхбаатар, Мөнххаан зэрэг сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нартай хамтран Монгол тарваганд хяналт хийхэд ямар нэгэн зөрчил бүртгэгдээгүй байна.

Аймгийн Экологийн цагдаагийн албанаас хийсэн шалгалтаар хууль бусаар цагаан зээр агнасан 3 тохиолдол бүртгэгдэж харьяаллын дагуу мэргэжлийн хяналтын газарт шилжүүлсэн. Дарьганга байгалийн цогцолборт хамгаалалтын захиргаанаас хийсэн хяналт шалгалтаар 1 иргэн ахуйн зориулалтаар зөвшөөрөлгүй тусгай хамгаалалттай газар нутгаас бургас бэлтгэсэнд 1.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан, 3 иргэн хууль бусаар цагаан зээр агнасныг илрүүлж хуулийн дагуу арга хэмжээ авч орлогыг төвлөрүүлсэн байна.

Ковид 19 цар тахлын улмаас 2021-2022 онуудад Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын үйл ажиллагааг хязгаарлаж төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг зогсоосон бөгөөд 2022 онд төлөвлөгөөт бус буюу иргэдээс ирсэн өргөдлийн дагуу шалгалт хийж 16 зөрчилд 5 албан шаардлага, 9 зөвлөмж хүргүүлж 2 аж ахуйн нэгжид хялбаршуулсан журмаар 0.8 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна. Аймгийн ГХБХБГ-аас Газрын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр Бичигт боомтод газар ашигласан, Сүхбаатар суманд шатахуун түгээх станц байгуулсан зөрчлүүдэд Зөрчлийн тухай хуулийн 8.1.10.1 /эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр газар ашигласан/ дэх заалтын дагуу 1.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2021-2022 онд ус зөвшөөрөлгүй ашигласан зөрчлийн илрүүлэлтийн талаарх мэдээллийг авч үзэхэд 2021 онд ус зөвшөөрөлгүй ашигласан уул уурхайн нэг компанид байгаль орчны хяналтын улсын байцаагч 1.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

БОАЖГ аймгийн хэмжээнд ус зөвшөөрөлгүй хэрэглэсэн, ашигласан зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг арилгуулах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулж, илэрсэн зөрчлийг холбогдох байгаль орчны хяналтын улсын байцаагчдаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

В.2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хийх хяналтыг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэвэл илүү үр дүнд хүрэх боломж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйл /Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх/, 16.1 дэх заалт /Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах

талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:/, 16.1.1 дэх заалт /нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;/ заалтын дагуу аймаг, сумдын ИТХ-аас 2021-2022 онуудад МУЗЗНДНТУ-ийн тухай хуулийн 21 /аймгийн чиг үүрэг/, 22 /сумын чиг үүрэг/ зүйлийн дагуу төлөвлөгөөт шалгалт 45 удаа хийж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллажээ.

Хяналтаар батлагдсан бус газар хадлан хадсан, бэлчээрт зөвшөөрөлгүй худаг гаргасан зэрэг зөрчлүүдэд урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж зөвшөөрөлгүй хадлангийн газраас газрын нөөцийн болон байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрт 21.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллагууд аймгийн ИТХ-ын 2022 оны 10-р сарын 01 өдрийн “Газрын төлбөрийн бүсийн хил зааг, итгэлцүүр, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 04 тоот тогтоолын дагуу газрын төлбөр төлөөгүй. Мөн ус ашиглах дүгнэлтгүй усны нөөц ашигласан, усны төлбөр төлөөгүй зэрэг зөрчлүүд байна. Иймд нутгийн өөрөө удирдах байгууллага хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар аймаг, сумдын төлөвлөгөөнд тусгуулж мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага байна.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:

**СҮХБААТАР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70518891

2023.06.20 № 152
танай 2023.06.16 -ны № 257 -т

Санал хүргүүлэх тухай

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцаад дараах саналыг хүргүүлж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтоон тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна гэж заасан байдаг.

Энэ нь манай аймгийн хувьд ус рашааны нөөц ашигласны төлбөрөөс өөр орлого орохгүй байгаа нөхцөлд байгаль хамгаалах бусад арга хэмжээг санхүүжүүлэх боломжгүй байдаг. Иймээс хууль журманд нөөц ашигласны орлого төвлөрүүлээгүй ч бусад хамгаалах шаардлагатай байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулж болохоор өөрчлөлт оруулах саналтай байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.НЯМХҮҮ

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Ирүүлсэн саналыг аудитын тайланд тусгаж, ҮАГ-т хүргүүлэх саналд орууллаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- БНАТТ хуулийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, төлбөрийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, зохицуулалтыг нарийвчлах зэргээр нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн байна.
- Аймаг, сум ойн менежментийн төлөвлөгөөгүйгээр ойн сан бүхий газарт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байна.
- Газрын төлбөрийн орлогын ногдуулалтыг дутуу хийсэн, зарим нийтийн эдэлбэр газар болон зам, шугам сүлжээ газрын зөвшөөрөлгүй, ус ашиглах дүгнэлтгүй, зөвшөөрөл аваагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд ус ашиглаж байна.
- Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээнээс багаар төлөвлөж батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн байгууллага нь байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээнд хяналт хийсэн боловч, төлбөрийн орлогын бүрдүүлэлт гарсан зардалд хяналт хийгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга, ЗДТГ-т:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн удирдах, БОАЖГ, СТСХ, ГХБХГ, Татварын хэлтэс, Усны сав газрууд, сумдын ЗДТГ болон холбогдох бусад байгууллагуудыг уялдаа холбоотой ажиллуулах чиглэлээр арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх.
2. Дөрвөлж ОНӨААТҮГ-ын шугамын усны алдагдлыг бууруулах чиглэлээр арга хэмжээг төлөвлөж зохион байгуулах.

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

1. Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлт хийхдээ сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө, ан амьтны менежментийн төлөвлөгөө, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө

болон бусад төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшний мэдээллийг бүрэн ашиглах.

2. Аймгийн хэмжээнд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулахад шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудаас тухай бүр гаргуулан авч, нэгтгэн, улирал бүр дүн шинжилгээ хийж ажиллах.
3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сумдад үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд сумдын холбогдох албан тушаалтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
4. Сүхбаатар аймгийн “Ойн менежментийн төлөвлөгөө”-г мэргэжлийн байгууллагаар хийлгэн Ойн газраар батлуулах, сумдыг “Ойн менежментийн төлөвлөгөө”-тэй болгох ажлыг төлөвлөж, зохион байгуулах.
5. Ус зөвшөөрөлгүй хэрэглэж, ашиглаж байгаа зөрчлийг арилгуулах чиглэлээр аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлж, ус ашигласны төлбөрийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу ногдуулах.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт:

1. Газрын зөвшөөрөлгүй нийтийн эдэлбэр газар болон зам, шугам сүлжээний газруудын зөрчлийг арилгуулах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, Газрын төлбөрийн тухай хуульд заасны дагуу төлбөр ногдуулах.

Татварын хэлтэст:

1. Байгаль орчны хяналтын улсын байцаагч, газрын хяналтын улсын байцаагч болон уул уурхайн хяналтын улсын байцаагч нартай мэдээлэл солилцох, хамтран ажиллах замаар байгалийн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтад хяналт тавьж, байгалийн нөөц ашигласны төлбөрийг бүрэн ногдуулахад чиглэсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх.
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт хийгдсэн боловч төлөөгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагаар төлүүлэхэд чиглэсэн шат дараалсан арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, төлөлтийг нэмэгдүүлэх.

Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19.1-д заасан хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бэлчээрийн ургамал ашигласны төлбөрөөс чөлөөлөх заалтыг хасуулж хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг уламжлах.

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг иргэн, хуулийн этгээд хуульд заасан хугацаанд бүрэн төлдөг болгохын тулд төрийн зарим төрлийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө тухайн иргэн, хуулийн этгээдэд ногдуулсан байгалийн нөөц ашигласны төлбөрийг хууль, шүүхийн маргаантайгаас бусад тохиолдолд төлсөн байх шалгуурыг холбогдох хууль тогтоомжуудад оруулах саналыг хүргүүлэх нь зүйтэй байна.
3. Ус, ой, ургамал, газар, ан амьтныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд нь өөр хоорондоо уялдаа холбоотой байдаг зөвхөн тухайн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ гэж хатуу хязгаарлах нь бодит байдалд нийцэхгүй байна. Иймд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д арга хэмжээний зориулалт, төрөл, төлбөрийн орлогын хувь хэмжээг уян хатан тусгуулах.
4. Агнуулах ан амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг БОАЖЯ төсвийн цаглабартай уялдуулан батлуулдаг болгох саналтай байна.

---oOo---